


ЗЭСИЙН БАЯЖМАЛ


01

Баяжуулах үйлдвэрт
буталсан хүдэр
оруулна.



02

Баяжуулах үйлдвэрт хүдрийг
боловсруулж 25-30 хувийн
агууламжтай зэсийн баяжмал
гаргана. Энэ баяжмалд маш
бага хувьтай зэс, алт, мөнгө,
молибден агуулагддаг.



03

Гуравдагч байгууллагын
бие даасан шинжилгээгээр
зэсийн баяжмалын чанарыг
баталгаажуулснаар металл
тус бүрээс ямар хэмжээгээр
борлуулах мэдээллийг
Засгийн газар авна.



04

Зэсийн баяжмалыг олон
улсын зах зээлийн үнээр
хэрэглэгчдэд худалдаалах
баримт бичигт гарын үсэг
зурсан



05

Баяжмалыг хилийн боомт дахь Оюу Толгой компанийн агуулах
руу тээвэрлэж, төлбөр авсны дараа хэрэглэгчдэд нийлүүлнэ.



6а


Засгийн газарт ашигт
малтмал ашигласны
төлбөр (Роялти) төлнө

6б

Хайлуулах болон дахин боловсруулах
үйлдвэрүүд зэсийн баяжмалыг цэвэр
металлын хэлбэрт хөрвүүлнэ

07

Металлуудыг барилгын ажил болон
электрон ба дэлхий даяар хэрэглэгдэх бусад
бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглана



ЗЭС БА ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

Зэсийг цахилгаан бараа, машин техник гээд өдөр тутмын амьдралдашигладаг. Бидний гэрийг гэрэлтүүлэх цахилгаан, хотыг босгох дэд бүтэц, дэлхий ертөнцийг холбог технологи, энэ бүгд нь бидний орчин үеийн амьдралыг бий болгоход зэс хэрхэн чухал байдгийг харуулж байна.

Дэлхийн жилийн зэсийн хэрэглээ 19 сая гаруй тонн. Дэлхийн томоохон эдийн засагтай орнуудад хотжилт, аж үйлдвэрлэлжүүлэлт үргэлжилж байгаа тул боловсруулсан зэсийн эрэлт хэрэгцээ нь 2020 он гэхэд нэмэлт 6.5 сая тонноор өсч 25.5 сая тонн хүрэх тооцоо бий. Үүнээс 19 сая тонныг олборлосон зэсээр, харин үлдэх хэсгийг хаягдлаар хангана.

Олон Улсын Зэсийн Холбоо нь АНУ-ын айл бүрт утас, кабель, хоолой, сантехник, цахилгаан бараа

бүтээгдэхүүн, бусад техникийг оролцуулан дунджаар 199 кг зэс бий гэсэн тооцоо гаргасан. Тэгэхээр Рио Тинто компани 2011 онд 2.6 сая айлын хэрэглээг хангах зэс үйлдвэрлэсэн гэсэн үг.

Өндөр агууламжтай зэсийн хүдэр бол олборлоход хамгийн хэцүү материал мөн. Олон зуун жилийн туршзэс нь дэлхийн хамгийн эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн байлаа. Уян, бат бөх, зэврэлд тэсвэртэй, эрүүл ахуйд сайн, дулаан болон цахилгааныг сайн дамжуулагч зэс бол бидэнд хамгийн ашигтай, хамгийн өргөн хэрэглээтэй метал мөн билээ.

Эртний Египтийн фараонуудын зэс хоолойгоос эхлэн Лондоны 2012 оны Олимпийн болон Паралимпийн тоглолтын үеэр гардуулсан 4700 медаль хүртэл, хаашаа ч харахад бид зэс эсвэл зэсийг дахин

Зэс үйлдвэрлэх нь

Зэсийг ил эсвэл далд уурхайгаас олборлосон хүдрээс гаргаж авдаг. Оюу Толгойн хувьдаль алийг нь ашиглах юм. Хүдрийг уурхайгаас олборлосны дараахь зэс үйлдвэрлэх үйл явц нь хэд хэдэн үе шатаар дамждаг.

Буталсан зэсийн хүдрийг нарийн нунтаглаж, дараа нь баяжуулж, хайлуулж, дахин цэвэршүүлэлт хийдэг. Үе шат бүр дээрзэсийн агууламжийг нэмэгдүүлж, хольцыг зайлуулдаг. Энэхүү процессын дайвар бүтээгдэхүүн бол алт, мөнгө, молибден байна. Эцэст нь, 99.99

хувийн сорьцтой цэвэр зэс бий болно. Оюу Толгойд төслийн талбай дахь боловсруулалт бол баяжуулах үе шатанд зогсож, борлуулах бүтээгдэхүүн нь зэсийн баяжмал байна.



боловсруулах процессын үр дүнд бий болсон металыг олж харж болно. Өнөөдөр чногоон технологийн шинэчлэлийгтэргүүлж буй метал бол зэс мөн билээ. Холимог болон цахилгаан хөдөлгүүрт машин, нарны эрчим хүч, салхины цахилгаан станц, дулааны болон усан цахилгаан станц зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд мөн л зэсээс

хамаарна.

Хэрэгцээтэй үед халдаг усны халаагуур, нарны зай, ухаалах цахилгаан утас, кабель зэрэг зүйлд ашиглагдах зэс бол ирээдүйн ногоон гэрийн салшгүй хэсэг болж, эрчим хүчний илүү хэмнэлттэй ирээдүй рүү шилжихэд бидэнд туслана.

